ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/26/-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Бүжинханд<br>Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn<br>Аудитор: Б.Цэвэлмаа<br>Утас:99026016 Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....10
3. Аудитын тайлан ....12
3.1 Ерөнхий зүйл ....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....12
3.4 Материаллаг байдал ....13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....14
3.8 Аудитын гол асуудал ....14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....15
4. Аудитын илрүүлэлт ....15
4.1 Залруулсан алдаа ....15
4.2 Төлбөрийн акт ....16
4.3 Албан шаардлага ....16
4.4 Зөвлөмж ....17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....17

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 72

танай ____________ -ны № ____________ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АРДЫН ДУУ
БҮЖГИЙН АЛТАЙ ЧУУЛГЫН ДАРГА
Э.ОТГОНБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хандиваар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, татварын тодорхойлолтоор илүү, дутуу төлөлт цахим системд бүртгэлтэй, төсвийн хэмнэлтийн талаар баримтлах арга хэмжээг баримтлаагүй тавилга бэлтгэсэн, ажилчдын цалингаас суутгал хийсэн зэрэг 125.5 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

07020369

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **234,309,697.44** | **263,974,262.00** |
| **33** | **АВЛАГА** | **66,191,816.44** | **82,226,937.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,677,501.44 | 1,184,912.00 |
| **33500** | **Бусад авлага** | **60,514,315.00** | **81,042,025.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 2,500,000.00 | 6,020,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 58,014,315.00 | 75,022,025.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **168,117,881.00** | **181,747,325.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **117,546,590.00** | **126,242,849.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 117,546,590.00 | 126,242,849.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **50,571,291.00** | **55,504,476.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 199,500.00 | 399,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 46,603,391.00 | 50,116,691.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 953,585.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,832,500.00 | 1,383,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,935,900.00 | 2,651,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,497,763,151.92** | **6,382,874,562.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **6,497,763,151.92** | **6,382,874,562.10** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **6,454,716,962.21** | **6,325,413,272.24** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,811,518,566.49 | 5,811,518,566.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -193,717,285.44 | -266,361,267.48 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,600,000.00 | 75,773,913.04 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,680,000.00 | -49,453,913.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 489,204,922.00 | 451,468,949.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -231,195,446.49 | -223,811,017.03 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 398,789,241.82 | 409,183,057.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -49,864,243.34 | -70,454,497.33 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 198,552,906.00 | 232,742,856.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -641,698.83 | -45,343,375.19 |
| 39217 | Ном | 150,000.00 | 150,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **43,046,189.71** | **57,461,289.86** |
| 39301 | Програм хангамж | 1,392,500.00 | 1,392,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,302,666.83 | -1,392,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 100,820,989.00 | 116,622,589.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -57,864,632.46 | -59,161,299.14 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,732,072,849.36** | **6,646,848,824.10** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **4,239,737.73** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **4,239,737.73** |
| **41300** | **Өглөг** | **0.00** | **4,239,737.73** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 4,139,737.73 |
| **41360** | **Бусад өглөг** | **0.00** | **100,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 100,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,732,072,849.36** | **6,642,609,086.37** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **6,732,072,849.36** | **6,642,609,086.37** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,281,195,233.00 | 4,281,195,233.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,696,806,477.80** | **1,607,342,714.81** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,215,305,033.48 | 1,696,806,477.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 481,501,444.32 | -89,463,762.99 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 754,071,138.56 | 754,071,138.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,732,072,849.36** | **6,646,848,824.10** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,965,091,923.00** | **1,368,971,613.04** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **206,934,507.00** | **49,448,313.04** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **206,934,507.00** | **49,448,313.04** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **206,934,507.00** | **49,448,313.04** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 4,720,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 206,934,506.00 | 44,728,313.04 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,758,157,416.00** | **1,319,523,300.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **49,596,216.00** | **27,120,100.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 49,596,216.00 | 23,620,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,708,561,200.00** | **1,292,403,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,708,561,200.00 | 1,292,403,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,514,490,478.68** | **1,458,435,376.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,514,490,478.68** | **1,458,435,376.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,486,226,412.43** | **1,448,170,302.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **748,945,646.48** | **681,540,969.77** |
| 210101 | Үндсэн цалин | 556,803,758.42 | 681,540,969.77 |
| 210102 | Нэмэгдэл | 65,573,760.54 | 0.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,752,694.21 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 74,815,433.31 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **95,500,340.19** | **89,663,839.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,608,262.42 | 63,113,112.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,560,841.05 | 7,016,461.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,701,770.23 | 5,517,320.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,370,551.47 | 1,271,837.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,258,915.02 | 12,745,107.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **362,606,107.64** | **395,336,995.27** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,830,679.64 | 13,091,936.27 |
| 210302 | Түлш, халаалт | 346,657,548.00 | 377,813,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,117,880.00 | 4,432,059.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,737,954.00** | **16,690,174.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,502,310.00 | 2,867,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,911,500.00 | 7,248,974.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,773,544.00 | 1,063,450.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,550,600.00 | 5,510,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **10,572,600.00** | **1,179,060.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,572,600.00 | 1,179,060.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,652,050.00** | **10,656,950.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,037,600.00 | 1,301,500.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 37,850.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 64,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,614,450.00 | 9,253,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,249,100.00** | **3,532,800.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,249,100.00 | 3,532,800.00 |

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **28,629,100.00** | **16,113,828.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,902,900.00 | 15,715,928.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250,000.00 | 249,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 123,000.00 | 123,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 25,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 755,200.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **189,333,514.12** | **233,455,685.86** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,573,544.00 | 1,049,757.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,380,200.00 | 1,134,280.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 179,379,770.12 | 231,271,648.86 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,264,066.25** | **10,265,073.91** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **16,650,000.00** | **8,458,020.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,650,000.00 | 8,458,020.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **11,614,066.25** | **1,807,053.91** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,553,487.67 | 1,807,053.91 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 60,578.58 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **450,601,444.32** | **-89,463,763.01** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **30,900,000.00** | **0.00** |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 30,900,000.00 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **481,501,444.32** | **-89,463,763.01** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,281,195,233.00** | **754,071,138.56** | **1,215,305,033.48** | **6,250,571,405.04** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,281,195,233.00** | **754,071,138.56** | **1,215,305,033.48** | **6,250,571,405.04** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **481,501,444.32** | **481,501,444.32** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,281,195,233.00** | **754,071,138.56** | **1,696,806,477.80** | **6,732,072,849.36** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **4,281,195,233.00** | **754,071,138.56** | **1,696,806,477.80** | **6,732,072,849.36** |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,281,195,233.00** | **754,071,138.56** | **1,696,806,477.80** | **6,732,072,849.36** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -89,463,762.99 | -89,463,762.99 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **4,281,195,233.00** | **754,071,138.56** | **1,607,342,714.81** | **6,642,609,086.37** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,758,157,417.00** | **1,320,723,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 0.00 | **1,200,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 0.00 | **1,200,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 0.00 | **1,200,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 1,200,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,758,157,416.00** | **1,319,523,300.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **49,596,216.00** | **27,120,100.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 3,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 49,596,216.00 | 23,620,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,708,561,200.00** | **1,292,403,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,708,561,200.00 | 1,292,403,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,682,053,727.00** | **1,249,068,554.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,682,053,727.00** | **1,249,068,554.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,653,699,660.75** | **1,238,836,000.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **789,209,937.20** | **690,001,091.96** |
| 210101 | Үндсэн цалин | 597,068,049.14 | 592,480,422.25 |
| 210102 | Нэмэгдэл | 65,573,760.54 | 50,960,669.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,752,694.21 | 46,560,000.00 |
| 210104 | Урамшуулал | 74,815,433.31 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **87,028,215.91** | **89,479,099.86** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,136,138.14 | 61,867,099.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,560,841.05 | 6,903,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,701,770.23 | 5,522,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,370,551.47 | 1,593,158.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,258,915.02 | 13,593,441.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **612,361,459.64** | **395,336,995.27** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,830,679.64 | 13,091,936.27 |
| 210302 | Түлш, халаалт | 596,412,900.00 | 377,813,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,117,880.00 | 4,432,059.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,759,454.00** | **19,318,456.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,502,310.00 | 3,067,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,911,500.00 | 8,199,859.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,773,544.00 | 1,023,850.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,572,100.00 | 7,027,597.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **13,648,800.00** | **2,500,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,648,800.00 | 2,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **44,833,350.00** | **11,761,480.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,706,400.00 | 2,432,000.00 |
| 210602 | Тавилга | 150,000.00 | 384,980.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 340,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,976,950.00 | 8,604,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,249,100.00** | **3,532,800.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,249,100.00 | 3,532,800.00 |

Говь-Алтай аймгийн ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **60,909,600.00** | **24,707,120.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 59,183,400.00 | 24,309,220.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250,000.00 | 249,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 123,000.00 | 123,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 25,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 755,200.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **18,699,744.00** | **2,198,957.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,700,544.00 | 1,049,757.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,999,200.00 | 1,149,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,354,066.25** | **10,232,553.91** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **16,740,000.00** | **8,425,500.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,740,000.00 | 8,425,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **11,614,066.25** | **1,807,053.91** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,553,487.67 | 1,807,053.91 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 60,578.58 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **76,103,690.00** | **71,654,746.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **76,103,690.00** | **71,654,746.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **76,103,690.00** | **71,654,746.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **76,103,690.00** | **71,654,746.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 76,103,690.00 | 71,654,746.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-76,103,690.00** | **-71,654,746.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0.00** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ЭЗА | Үзүүлэлт | Тайлант оны | Цэвэр гүйцэтгэл | Төсвийн хэмнэлт+, хэмнэлт- | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,292,403,200.0** | **1,291,946,146.09** | **457,053.91** | **100%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,292,403,200.0 | 1,291,946,146.1 | 457,053.9 | **100%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,287,203,200.0 | 1,286,746,146.09 | 457,053.9 | **100%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 690,299,000.0 | 690,001,091.96 | 297,908.0 | **100%** |
| 210101 | Үндсэн цалин | 690,299,000.0 | 592,480,422.25 | 97,818,577.8 | **86%** |
| 210102 | Нэмэгдэл | - | 50,960,669.71 | (50,960,669.7) | **#DIV/0!** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 46,560,000.00 | (46,560,000.0) | **#DIV/0!** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 89,479,100.0 | 89,479,099.86 | 0.1 | **100%** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,867,100.0 | 61,867,099.86 | 0.1 | **100%** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,903,000.0 | 6,903,000.00 | - | **100%** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,522,400.0 | 5,522,400.00 | - | **100%** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,380,600.0 | 1,593,158.58 | (212,558.6) | **115%** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,806,000.0 | 13,593,441.42 | 212,558.6 | **98%** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 393,906,000.0 | 393,851,995.27 | 54,004.7 | **100%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,830,000.0 | 12,829,999.27 | 0.7 | **100%** |
| 210302 | Түлш, халаалт | 376,813,000.0 | 376,813,000.00 | - | **100%** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,263,000.0 | 4,208,996.00 | 54,004.0 | **99%** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,321,100.0 | 15,318,456.00 | 2,644.0 | **100%** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,600,000.0 | 3,067,150.00 | 532,850.0 | **85%** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,200,000.0 | 7,199,859.00 | 141.0 | **100%** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,074,100.0 | 1,023,850.00 | 50,250.0 | **95%** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,447,000.0 | 4,027,597.00 | (580,597.0) | **117%** |
| **2105** | **Нормативт зардал** | 2,800,000.0 | 2,800,000.00 | - | **100%** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,800,000.0 | 2,800,000.00 | - | **100%** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,200,000.0 | 24,199,046.00 | 954.0 | **100%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.0 | 4,999,300.00 | 700.0 | **100%** |
| 210602 | Тавилга | 11,200,000.0 | 11,199,746.00 | 254.0 | **100%** |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.0 | 8,000,000.00 | - | **100%** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,450,000.0 | 2,449,600.00 | 400.0 | **100%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,450,000.0 | 2,449,600.00 | 400.0 | **100%** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 67,448,000.0 | 67,447,900.00 | 100.0 | **100%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,050,000.0 | 67,050,000.00 | - | **100%** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250,000.0 | 249,900.00 | 100.0 | **100%** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 123,000.0 | 123,000.00 | - | **100%** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000.0 | 25,000.00 | - | **100%** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,300,000.0 | 1,198,957.00 | 101,043.0 | **92%** |

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.0 | 499,757.00 | 243.0 | **100%** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 800,000.0 | 699,200.00 | 100,800.0 | **87%** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,200,000.00 | 5,200,000.00 | - | **100%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,200,000.0 | 5,200,000.00 | - | **100%** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,200,000.0 | 5,200,000.00 | - | **100%** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,292,403,200.0** | **1,291,946,146.09** | **457,053.9** | **100%** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,292,403,200.0 | 1,290,746,146.09 | 1,657,053.9 | **100%** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,292,403,200.0 | 1,290,746,146.09 | 1,657,053.9 | **100%** |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 1,200,000.00 | (1,200,000.0) | **#DIV/0!** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,200,000.00 | (1,200,000.0) | **#DIV/0!** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **69.00** | **69.00** | **69.00** | 0% |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн ййлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 50.00 | 50.00 | 50.00 | 100% |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 19.0 | 69.00 | 69.00 | 0% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **27,120,100.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | 27,120,100.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 23,744,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 1,485,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 261,937.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 1,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 223,063.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 4,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 3,604,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,500,000.00 |
| 210602 | Тавилга | | 1,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 500,000.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | | 604,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 1,083,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,083,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 12,571,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 12,571,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 1,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 550,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 450,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 3,375,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 3,225,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 3,225,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 150,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 150,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **27,120,100.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 27,120,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 3,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 23,620,100.00 |

Говь-Алтай аймаг дахь ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ардын дуу бүжгийн Алтай чуулга нь мэргэжлийн соёл, урлагийн үйлчилгээг, ард иргэдэд мэргэжлийн түвшинд хүргэх зорилготой ажилладаг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,514.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 33.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26.9 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулгын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1 хувиар буюу 85.2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 82.2 сая төгрөг болж 16.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд шүүхийн шийдвэрийн цалингийн нөхөн олговрын 18.2 сая, байгууллагаас авах 3.5 сая төгрөгийн авлага шинээр нэмэгдсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 181.7 сая төгрөг болж 13.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 29.0 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,098.9 сая төгрөг болж 64.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 71.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 44.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 51.6 сая төгрөгийн хөрөнгийн акталж данснаас хассантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 4.2 сая төгрөг нь хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,642.6 сая төгрөг болж 89.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 30 хувиар буюу 596.1 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,607.3 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 535.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 176.7 сая төгрөгөөр бууруулж, 1,292.4 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь цалингийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, томилолт, зочны зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 1,292.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,292.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 1.2 сая төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 1,291.9 сая төгрөгийг зарцуулж 1.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,291.9 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 0.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 27.1 сая төгрөгийн орлого хүлээн авч, 1.5 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 4.0 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 3.6 сая төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 1.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг зардалд, 3.2 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 6.0 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтгүй худалдан авалт хийснийг аудитын явцад залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 3.1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 53.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 184.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 58.7 сая төгрөгийн алдааг залруулж, 125.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор данснаас хасаж актлах тухай шийдвэр гарсан 51.6 төгрөгийн үндсэн хөрөнгийг хөдлөл өөрчлөлтийг хийгээгүй, шүүхийн шийдвэрийн цалингийн нөхөн олговрын 1.2 сая төгрөгийн авлагыг дутуу тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Мөн 6.0 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

**4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоосон алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

**4.3 Албан шаардлага**

Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 45.3 сая төгрөгийн авлага, хувь хүнээс авах 33.4 сая төгрөгийн авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй, барагдаагүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.", Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 12.7 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 10.0 сая төгрөгийн хандивыг материалыг данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." гэж заасныг зөрчсөн, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 8.8 сая төгрөгийн тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Татварын тодорхойлолтоор 5.0 сая төгрөгийн дутуу, 7.9 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр

зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Ажилчдын цалингаас тоглолтын билетийн үнэ 2.4 сая төгрөгийг суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйл "Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

**4.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

| | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн Алтай чуулга | 9 | 184.2 | 3 | 58.7 | 0 | 0 | 6 | 125.5 | 0 | 0 |